ИНВЕСКОР ГЛОБАЛ КЬЮ ХБА ХОС

2025 ОН

INQ ETF

2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

INVESCORE GLOBAL Q

InvesCore Asset

МЭНДЧИЛГЭЭ БА ЭРСДЭЛИЙН САНАМЖ

Ирээдүйн зорилгоо биелүүлэхээр ухаалаг хөрөнгө оруулалтыг сонгож буй эрхэм хөрөнгө оруулагчид та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд хамгийн олон мэргэжлийн байгууллагууд оролцож анхны Хамтын Биржээр Арилжаалагддаг Хөрөнгө Оруулалтын Санг (ХБАХОС) үүсгэн байгуулсан. INQ ETF-ийн нэгж эрх 2023 оны 11 дүгээр сарын сүүлээр Улаанбаатар Үнэт Цаасны биржээр арилжаалагдаж эхэлсэн ба 2025 оны эцэст 566.24 төгрөгийн үнэлгээтэй хаагдсан буюу өмнөх оны мөн үеэс 19.39%-ийн өсөлттэй хаагдлаа.

2025 онд дэлхийн хөрөнгийн зах зээл оныг нэлээд тогтворгүй орчинд эхлүүлсэн. Тарифын маргаан хурцдаж, бодлогын тодорхой бус байдал нэмэгдсэн нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сулруулж, оны эхний саруудад хүчтэй зарах дараалал болон өндөр хэлбэлзлийг бий болгосон. Гэсэн хэдий ч энэхүү тогтворгүй үеийн дараа зах зээл аажмаар тогтворжиж, жилийн хоёрдугаар хагаст өсөлтийн чиг хандлагаа сэргээж чадсан. Үүний үр дүнд Nasdaq 100 индекс 21.0%, S&P 500 индекс 17.9%-иар өссөн нь 2024 оны өгөөжөөс бага байсан ч оны эхний хүнд нөхцөлийг даван туулж, зах зээл тэсвэртэйгээр сэргэснийг харуулж байна.

2025 оны олон улсын хөрөнгийн зах зээлийн гүйцэтгэл (%)

	6 сарын*	12 сарын*
NASDAQ-100	18.32	21.00
S&P 500	15.32	17.90
Russell 2000	22.45	12.80
MSCI World Index	2.85	19.49
MSCI Emerging Markets Index	14.69	30.58

Өнгөрсөн үр дүнгийн гүйцэтгэл нь ирээдүйн гүйцэтгэлийн амлалт биш болохыг анхаарна уу.

*: 12 сарын гүйцэтгэл нь 2025 оны бүтэн жилийн гүйцэтгэл, 6 сарын гүйцэтгэл нь 2025 оны сүүлийн хагас жилийн гүйцэтгэл болно.

Эрсдэлийн санамж:

Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн үүсгэн байгуулах баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь уг нэгж эрхийн эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарна уу. Үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааны түүхэн гүйцэтгэл нь энэхүү сангийн ирээдүйн гүйцэтгэлийн баталгаа болохгүй. Сангийн нэгж эрхийг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ямагт эрсдэлтэй үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, нэгж эрхийн танилцуулга, нэгж эрх гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

АГУУЛГА

	Хуудас
Мэндчилгээ ба эрсдэлийн санамж	2
Үйл ажиллагааны тайлан:	
Сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, түүний гүйцэтгэл ба зардлын харьцаа үзүүлэлтүүд	4
Зах зээлийн тойм	8
Хөрөнгө оруулалтын сангийн бүтэц, зохион байгуулалт, засаглал	9
Хөрөнгө оруулалтын сангийн эрсдэлийн хүчин зүйлс, удирдлага	9
Санхүүгийн тайлан	10
Санхүүгийн байдлын тайлан	10
Орлогын дэлгэрэнгүй тайлан	11
Мөнгөн гүйлгээний тайлан	11
Аудитын тайлан	12

САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛ БА ЗАРДЛЫН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сангийн зорилго

“Инвескор Глобал Кью” Хамтын Биржээр Арилжаалагддаг ХОС-ийн зорилго нь АНУ-ийн Насдак 100 индексийн гүйцэтгэлийн дагаж, сангийн зардал тооцохын өмнөх түвшинд ижил гүйцэтгэлийг гаргах зорилготой ба үүний тулд индексийн бүрэлдэхүүнд орсон үнэт цаасанд хөрөнгө оруулах замаар ижил гүйцэтгэлийг хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Хөрөнгө оруулалтын стратеги

ХОМК нь ХБАХОС-ийн зорилгод хүрэхийн тулд сангийн зуучлалын зардлыг хамгийн бага хэмжээнд байлгах, индекс дагах алдааг хамгийн бага байлгахын тул сангийн хөрөнгийн хэмжээ, хөрөнгө оруулсан үнэт цаасны хөрвөх чадвар, зуучлалын хөлсний хэмжээг харгалзан үзэж доорх стратегиудаас сонгож ажиллана. Үүнд:

- ✓ **Бүрэн хуулбарлах стратеги:** “Бүрэн Хуулбарлах” гэдэг нь дагаж буй индексийн бүрэлдэхүүнд орсон хувьцаа бүрийг нндексийн хувийн жингээр, ижил цаг хугацаанд шууд болон шууд бусаар хөрөнгө оруулалт хийх стратеги,
- ✓ **Түүврээр төлөөлүүлэх стратеги:** Тухайн индексийн бүрэлдэхүүнд багтсан Үнэт цаасны төлөөллөөс түүвэрлэн шууд болон шууд бусаар хөрөнгө оруулалт хийн индексийн гүйцэтгэлтэй адил гүйцэтгэл үзүүлэх стратеги юм.

Сан нь түүврээр төлөөлөн дагах стратегийг хэрэгжүүлж буй бөгөөд индексийн гүйцэтгэлийг дагаж байна. Сангийн хөрөнгийн 98%-иас доошгүй хувьд индексийн хувьцааг худалдан авах, үлдсэн хувьд мөнгөний зах зээлийн хэрэгсэлд байршуулдаг.

Хөрөнгө оруулалтын багцын нийт активыг тооцох аргачлал

INQ сангийн бүртгэл ажлын өдөр бүр өглөөний 9:00 цагаас хийгддэг ба нийт хөрөнгийн хэмжээ Alternative Trading System болох биржийн бус алтернатив зах зээлийн хувьцаануудын хаалтын ханшаар бодогддог. Мөн хувьцааны багцыг төгрөгөөр илэрхийлэхийн тулд Монгол Улсын системийн 5 том банк буюу Хаан Банк, Худалдаа Хөгжлийн Банк, Голомт Банк, Төрийн Банк ба Хас Банкны бэлэн бус ам.долларын зарах дундаж ханшаар бодно.

Улаанбаатар Үнэт Цаасны Биржийн өдөр бүр мэдээлдэг нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ буюу Net Asset Value (NAV) нь сангийн нийт хөрөнгөнөөс сангийн үйл ажиллагааны болон бусад зардлуудыг хассан дүн болно.

Гүйцэтгэл (%)

	Жилийн дундаж гүйцэтгэл				
	1 жил	**3 жил**	**5 жил**	**10 жил**	**11/29/2023-с хойш**
Nasdaq 100	20.17	130.81	95.91	449.71	57.93
INQ – Үнэ	-	-	-	-	(24.00)
INQ - NAV	-	-	-	-	13.25

1: нэгж эрхэд ноогдох нийт хөрөнгийн дүнгээс үйл ажиллагааны болон бусад зардлуудыг хассан дүн.
2: 11/29/2023 нооc 12/31/2025 хүртэлх үзүүлэлтүүд

Энэхүү график нь 2023 оны 11-р сарын 29-нээс буюу сангийн үйл ажиллагаа эхлэх өдрөөс хойших дата дээр суурилсан болно. INQ ETF-ийн гүйцэтгэл Насдак 100 индексийн гүйцэтгэлээс бага байгаа нь хуримтлагдсан зардал нийт хөрөнгөд эзлэх хувь өндөр байгаатай холбоотой байна.

Эрсдэлийн үзүүлэлт/стандарт хазайлт (%)

	11/29/2023-с хойш /нэг өдрийн/
Nasdaq 100	1.10
INQ-үнэ	1.77
INQ-NAV	1.68

Стандарт хазайлт нь үнэ цэний хэлбэлзлийг тоогоор илэрхийлсэн үзүүлэлт ба өндөр байх тусам их хэлбэлзлийг харуулна. Энэхүү үзүүлэлтийг хөрөнгө оруулалтуудын эрсдэлийг харьцуулахад ашигладаг.

Сангийн зардлын бүтэц

Сангийн үйл ажиллагааны мөнгөн зарлага нь 2025 онд төгрөг байсан ба нийт жигнэсэн дундаж хөрөнгийн **7.25%-**ийг эзэлж байна.

2025 оны бүтэн жилийн зардал (Нийт хөрөнгөд эзлэх %)	**%**
Менежментийн үйлчилгээний зардал	1.00%
Кастодианы үйлчилгээний зардал	0.77%
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	0.06%
Бусад зардал	5.42%
Нийт зардал	**7.25%**

Энэхүү хүснэгт нь INQ ETF-ийн 2025 оны нийт жилийн зардлын бүтцийг харуулна. Бусад зардалд аудит болон нягтлан бодох бүртгэлийн зардлууд тусгагдсан болно.

Багцын 10 том бүрдэл хувьцаанууд (%) /Нийт хувьцааны тоо хэмжээ: 42 /

№	Хувьцаа	Симбол	Үнэлгээ / 12/30/2025 /	Хувийн жин /%/
1	NVIDIA Corporation	NVDA	$ 6,563.90	13.67%
2	Apple Inc	AAPL	$ 6,007.76	12.51%
3	Alphabet Inc Class C	GOOG	$ 5,034.88	10.49%
4	Microsoft Corporation	MSFT	$ 4,387.77	9.14%
5	Amazon.com Inc	AMZN	$ 3,487.95	7.26%
6	Broadcom Inc	AVGO	$ 2,099.10	4.37%
7	Meta Platforms Inc	META	$ 1,997.85	4.16%
8	Tesla Inc	TSLA	$ 1,362.72	2.84%
9	Advanced Micro Devices Inc	AMD	$ 1,076.70	2.24%
10	ASML Holding NV ADR	ASML	$ 1,072.14	2.23%
	Нийт		**$ 33,090.77**	**68.92%**



Секторын тархалт (%)

№	Салбарын нэр	Багцад эзлэх хувийн жин /%/	Индекст эзлэх хувийн жин /%/
1	Технологи	70.85%	70.02%
2	Тансаг хэрэглээ	20.23%	20.57%
3	Эрүүл мэнд	2.35%	2.83%
4	Өргөн хэрэглээ	1.16%	1.40%
5	Энгийн материал	1.78%	0.66%
6	Харилцаа холбоо	2.86%	2.25%
7	Ашиглалт	0.37%	0.84%

Газар зүйн тархалт (%)

АНУ	94.12
Европ	4.93
БНХАУ	0.95

Европ: ASML Holding NV ADR – 2.23%, Linde PLC - 1.78%, NXP Semiconductors NV - 0.92%

8	Аж үйлдвэр	0.41%	1.33%
9	Эрчим хүч	-	0.15%

Хөрөнгө оруулалтуудын жагсаалт (ам.доллар) /2025 оны 12-р сарын 31-ний байдлаар/

№	Хувьцаа	Симбол	Тоо ширхэг	Хаалтын ханш /12/30/2025/	Үнэлгээ /12/31/2025/	Хувийн жин / % /
1	NVIDIA Corporation	NVDA	35	**187.54**	6,563.90	13.67%
2	Apple Inc	AAPL	22	**273.08**	6,007.76	12.51%
3	Alphabet Inc Class C	GOOG	16	**314.68**	5,034.88	10.49%
4	Microsoft Corporation	MSFT	9	**487.53**	4,387.77	9.14%
5	Amazon.com Inc	AMZN	15	**232.53**	3,487.95	7.26%
6	Broadcom Inc	AVGO	6	**349.85**	2,099.10	4.37%
7	Meta Platforms Inc	META	3	**665.95**	1,997.85	4.16%
8	Tesla Inc	TSLA	3	**454.24**	1,362.72	2.84%
9	Advanced Micro Devices Inc	AMD	5	**215.34**	1,076.70	2.24%
10	ASML Holding NV ADR	ASML	1	**1,072.14**	1,072.14	2.23%
11	Alphabet Inc Class A	GOOGL	3	**313.85**	941.55	1.96%
12	Netflix Inc	NFLX	10	**93.78**	937.8	1.95%
13	PACCAR Inc	PCAR	8	**110.96**	887.68	1.85%
14	Costco Wholesale Corp	COST	1	**865.65**	865.65	1.80%
15	Linde PLC	LIN	2	**428.36**	856.72	1.78%
16	PayPal Holdings Inc	PYPL	12	**59.1**	709.2	1.48%
17	Cisco Systems Inc	CSCO	9	**77.41**	696.69	1.45%
18	Intuit Inc	INTU	1	**669.88**	669.88	1.40%
19	Amgen Inc	AMGN	2	**328.61**	657.22	1.37%
20	Palantir Technologies Inc	PLTR	3	**180.84**	542.52	1.13%
21	Applied Materials Inc	AMAT	2	**259.97**	519.94	1.08%
22	DexCom Inc	DXCM	7	**67.06**	469.42	0.98%
23	PDD Holdings Inc DRC	PDD	4	**113.81**	455.24	0.95%
24	Verisk Analytics Inc	VRSK	2	**224.36**	448.72	0.93%
25	NXP Semiconductors NV	NXPI	2	**219.98**	439.96	0.92%
26	PepsiCo Inc	PEP	3	**144.16**	432.48	0.90%
27	T-Mobile US Inc	TMUS	2	**203.8**	407.6	0.85%
28	Adobe Systems Incorporated	ADBE	1	**352.51**	352.51	0.73%
29	Texas Instruments Incorporated	TXN	2	**175.42**	350.84	0.73%
30	Qualcomm Incorporated	QCOM	2	**173.65**	347.3	0.72%
31	Intel Corporation	INTC	9	**37.3**	335.7	0.70%
32	Copart Inc	CPRT	8	**39.5**	316	0.66%
33	Cadence Design Systems Inc	CDNS	1	**315.6**	315.6	0.66%
34	Micron Technology Inc	MU	1	**292.63**	292.63	0.61%
35	Airbnb Inc	ABNB	2	**136.91**	273.82	0.57%
36	Comcast Corp	CMCSA	9	**29.97**	269.73	0.56%
37	Paychex Inc	PAYX	2	**113.39**	226.78	0.47%
38	ON Semiconductor Corporation	ON	4	**54.24**	216.96	0.45%
39	Honeywell International Inc	HON	1	**196.36**	196.36	0.41%
40	Cintas Corporation	CTAS	1	**190.35**	190.35	0.40%
41	Exelon Corporation	EXC	4	**43.92**	175.68	0.37%
42	Kraft Heinz Co	KHC	5	**24.43**	122.15	0.25%

Нийт		**$ 48,011.45**	**100%**

Эх сурвалж: Bloomberg Terminal

Хөрөнгө оруулалтуудын жагсаалт (төгрөг) /2025 оны 12-р сарын 31-ний байдлаар/

5 Банкны ам.долларын бэлэн бус зарах дундаж ханш (MNT/USD): 3,556.66 MNT/USD

№	Хувьцаа	Симбол	Тоо ширхэг	Хаалтын ханш / 12/30/2025 /	Үнэлгээ / 12/30/2025 /	Хувийн жин / % /
1	NVIDIA Corporation	NVDA	35	**667,016.02**	23,345,560.57	13.67%
2	Apple Inc	AAPL	22	**971,252.71**	21,367,559.68	12.51%
3	Alphabet Inc Class C	GOOG	16	**1,119,209.77**	17,907,356.30	10.49%
4	Microsoft Corporation	MSFT	9	**1,733,978.45**	15,605,806.05	9.14%
5	Amazon.com Inc	AMZN	15	**827,030.15**	12,405,452.25	7.26%
6	Broadcom Inc	AVGO	6	**1,244,297.50**	7,465,785.01	4.37%
7	Meta Platforms Inc	META	3	**2,368,557.73**	7,105,673.18	4.16%
8	Tesla Inc	TSLA	3	**1,615,577.24**	4,846,731.72	2.84%
9	Advanced Micro Devices Inc	AMD	5	**765,891.16**	3,829,455.82	2.24%
10	ASML Holding NV ADR	ASML	1	**3,813,237.45**	3,813,237.45	2.23%
11	Alphabet Inc Class A	GOOGL	3	**1,116,257.74**	3,348,773.22	1.96%
12	Netflix Inc	NFLX	10	**333,543.57**	3,335,435.75	1.95%
13	PACCAR Inc	PCAR	8	**394,646.99**	3,157,175.95	1.85%
14	Costco Wholesale Corp	COST	1	**3,078,822.73**	3,078,822.73	1.80%
15	Linde PLC	LIN	2	**1,523,530.88**	3,047,061.76	1.78%
16	PayPal Holdings Inc	PYPL	12	**210,198.61**	2,522,383.27	1.48%
17	Cisco Systems Inc	CSCO	9	**275,321.05**	2,477,889.46	1.45%
18	Intuit Inc	INTU	1	**2,382,535.40**	2,382,535.40	1.40%
19	Amgen Inc	AMGN	2	**1,168,754.04**	2,337,508.09	1.37%
20	Palantir Technologies Inc	PLTR	3	**643,186.39**	1,929,559.18	1.13%
21	Applied Materials Inc	AMAT	2	**924,624.90**	1,849,249.80	1.08%
22	DexCom Inc	DXCM	7	**238,509.62**	1,669,567.34	0.98%
23	PDD Holdings Inc DRC	PDD	4	**404,783.47**	1,619,133.90	0.95%
24	Verisk Analytics Inc	VRSK	2	**797,972.24**	1,595,944.48	0.93%
25	NXP Semiconductors NV	NXPI	2	**782,394.07**	1,564,788.13	0.92%
26	PepsiCo Inc	PEP	3	**512,728.11**	1,538,184.32	0.90%
27	T-Mobile US Inc	TMUS	2	**724,847.31**	1,449,694.62	0.85%
28	Adobe Systems Incorporated	ADBE	1	**1,253,758.22**	1,253,758.22	0.73%
29	Texas Instruments Incorporated	TXN	2	**623,909.30**	1,247,818.59	0.73%
30	Qualcomm Incorporated	QCOM	2	**617,614.01**	1,235,228.02	0.72%
31	Intel Corporation	INTC	9	**132,663.42**	1,193,970.76	0.70%
32	Copart Inc	CPRT	8	**140,488.07**	1,123,904.56	0.66%
33	Cadence Design Systems Inc	CDNS	1	**1,122,481.90**	1,122,481.90	0.66%
34	Micron Technology Inc	MU	1	**1,040,785.42**	1,040,785.42	0.61%
35	Airbnb Inc	ABNB	2	**486,942.32**	973,884.64	0.57%
36	Comcast Corp	CMCSA	9	**106,593.10**	959,337.90	0.56%
37	Paychex Inc	PAYX	2	**403,289.68**	806,579.35	0.47%
38	ON Semiconductor Corporation	ON	4	**192,913.24**	771,652.95	0.45%
39	Honeywell International Inc	HON	1	**698,385.76**	698,385.76	0.41%
40	Cintas Corporation	CTAS	1	**677,010.23**	677,010.23	0.40%
41	Exelon Corporation	EXC	4	**156,208.51**	624,834.03	0.37%
42	Kraft Heinz Co	KHC	5	**86,889.20**	434,446.02	0.25%

Нийт	**₮ 170,760,403.76**	**100%**

Багц хувьцаануудын үзүүлэлтүүд (жигнэсэн дундаж, 2025 он)

Үнэ/Цэвэр ашиг (P/E) харьцаа	24.79
Өр/Эздийн өмч	0.70
Цэвэр ашгийн маржин	21.77
Эздийн өмчийн өгөөж	15.02%
Нийт хөрөнгийн өгөөж	5.83%

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Дэлхийн эдийн засаг

2025 он дэлхийн санхүүгийн зах зээлийн хувьд геополитикийн эрсдэлүүд болон томоохон улс орнуудын худалдааны бодлогын өөрчлөлтөөр тодорхойлогдлоо. АНУ-ын шинэ засаг захиргаанаас хэрэгжүүлж буй тарифын бодлого болон цагаачлалын шинэ зохицуулалтууд нь дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд томоохон савлагаа үүсгэв. Импортын барааны тариф нэмэгдсэн нь АНУ доторх үнийн түвшнийг өдөөж, улмаар Холбооны Нөөцийн банк (Fed) бодлогын хүүгээ бууруулах хурдаа сааруулсан нь ам.долларын ханш бусад валютуудын эсрэг чангарах нөхцөлийг бүрдүүллээ.

Олон Улсын Валютын Сан (ОУВС)-аас гаргадаг Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын шинэчилсэн тайланд 2026 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамаглалыг 3.0 хувь болгон бууруулсан нь геополитикийн нөхцөл байдал болон нийлүүлэлтийн сүлжээний тасалдалтай холбоотой юм. ОУВС Хятад улсын 2026 оны эдийн засгийн өсөлтийн таамгийг 4.1 хувь болгон дахин бууруулсан нь АНУ-ын худалдааны шахалт болон тус улсын технологийн салбарт тавьсан хориг арга хэмжээнүүдтэй шууд холбоотой. Харин АНУ-ын ирэх оны өсөлтийг 1.9 хувь байна хэмээн таамаглаж байгаа нь бодлогын хүүгийн түвшинийг удаан хадгалагдах хүлээлт дээр үндэслэгджээ.

Ойрхи Дорнод дахь Иран, Израил болон АНУ-ын оролцоотой мөргөлдөөнүүд 2025 оны турш дэлхийн эрчим хүчний аюулгүй байдалд гол эрсдэл учруулсан хэвээр байна. Улаан тэнгис болон стратегийн чухал усан замуудын аюулгүй байдал алдагдсанаас үүдэлтэй тээврийн зардлын өсөлт нь дэлхийн худалдааны идэвхжилд сөргөөр нөлөөлж, төв банкуудын инфляцтай тэмцэх ажилд хүндрэл учруулж байна.

Дэлхийн эдийн засаг 2025-2026 онуудад 3.2 хувийн өсөлттэй байх төлөвтэй байгаа ч улс орнуудын өрийн хэмжээ түүхэн дээд түвшинд (ДНБ-ий 93 хувь) хүрэхээр байгаа нь төсвийн тогтвортой байдлын асуудлыг хурцаар тавьж байна. Хөрөнгө оруулагчид ирэх жилүүдэд геополитикийн болон бодлогын эрсдэлүүдийг удирдахад гол анхаарлаа хандуулах шаардлагатай болж байна.

График. Төв банкуудын бодлогын хүүгийн төсөөлөл



Монгол Улсын эдийн засаг

2023-2024 оны турш үргэлжилсэн уул уурхайн салбарын огцом өсөлт нь экспортын орлого болон төсвийн бүрдүүлэлтийг үлэмж нэмэгдүүлж, Монгол Улсын эдийн засгийн гадаад болон төсвийн эмзэг байдлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Гэсэн хэдий ч 2025 оны эхний хагаст нүүрсний экспортын хэмжээ мэдэгдэхүйц буурсан нь урсгал дансны алдагдал тэлэх, төсвийн орлого тасалдах болон үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид ирэх дарамтыг нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болов.

2026 оны эдийн засгийн бодит өсөлт 5.5 хувьд хүрэх төлөвтэй байгаа бөгөөд үүнд хөдөө аж ахуйн салбарын хүчтэй сэргэлт голлон нөлөөлж байна. Уул уурхайн салбарын хувьд Оюу Толгой төслийн гүний уурхайн өндөр агуулгатай зэсийн баяжмалын олборлолт нэмэгдэж байгаа нь салбарын идэвхжлийг хадгалахад дэмжлэг болж байгаа хэдий ч нүүрсний үнийн уналтаас шалтгаалж экспортын орлого буурсан нь төсвийн болон урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлээд байна. Инфляцын түвшин 2025 оны 2-р сард оргил үедээ хүрснээс хойш саарч, 6-р сарын байдлаар 8.2 хувьд хүрсэн ч Төв банкны зорилтот түвшнээс дээгүүр хэвээр байна. Банк болон банк бус санхүүгийн салбарын зээлийн өсөлт бага зэрэг саарсан ч өндөр түвшинд хадгалагдсаар байна.

2025 оны 6-р сард байгуулагдсан шинэ Засгийн газар өмнөх Засгийн газрын бодлогуудыг үргэлжлүүлэхээ мэдэгдсэн бөгөөд төсвийн орлогын тасалдлын хариуд зардлыг танах, төсвийн бүтцийн алдагдлын хязгаарыг мөрдөх зорилгоор төсвийн тодотголыг УИХ-д өргөн барисан. Дунд

хугацаанд Монгол Улсын эдийн засгийн өсөлт 5 орчим хувьд тогтворжихоор байгаа ч урсгал дансны алдагдал хөрөнгө оруулалтын төслүүдийн импортын өндөр хамаарал болон хэрэглээний барааны импортын өсөлтөөс шалтгаалан хадгалагдсаар байх төлөвтэй.

Эдийн засгийн төлөв байдалд сөргөөр нөлөөлж болохуйц гадаад эрсдэлүүд нэмэгдэж байна. Үүнд:

- БНХАУ-ын эрэлт: Хятадын зах зээл дэх нүүрсний эрэлтийн тодорхойгүй байдал болон нүүрсний үнийн огцом уналт;
- Төсвийн сахилга бат: Уул уурхайн үр өгөөжийг хуваарилах шахалт нэмэгдэж байгаатай холбоотойгоор татварын цуглуулалт буурах болон томоохон төслүүдийг төсвийн дүрмээс чөлөөлөх хандлага нь шинэчлэлийн үр дүнг сааруулах эрсдэлтэй байна.

Цаашид эдийн засгийн дархлааг бэхжүүлэхийн тулд төсвийн дүрмийг чанд мөрдөж, мөнгөний хатуу бодлогыг 2026 он хүртэл буюу инфляц зорилтот түвшинд хүртэл хадгалах нь чухал болоод байна.

НАСДАК-100 индексийн 2026 оны төсөөлөл

Насдак-100 индекс 2025 оны гүйцэтгэлээр технологийн салбарын хүчирхэг өсөлтийг хадгалж, хөрөнгө оруулагчдын итгэлийг бататгасан жил боллоо. Энэхүү өсөлтөд хиймэл оюун ухааны (AI) технологийн туршилтын үе дуусч, бодит хэрэглээ болон ашигт ажиллагаанд нөлөөлж эхэлсэн нь гол түлхэц болсон юм. Уол Стрийтийн шинжээчдийн үзэж буйгаар 2026 онд Насдак-100 индекс өсөлтийн чиг хандлагаа хадгалах төлөвтэй байна.

2026 онд индексийн өсөлтийг тодорхойлох гол компаниудад Nvidia, Microsoft, Palantir, Tesla, Google, Apple болон өгөгдлийн бааз, үүлэн тооцооллын чиглэлээр тэргүүлэгч MongoDB, Pegasystems, Snowflake, Salesforce зэрэг компаниудыг онцолж байна. Эдгээр компаниуд AI-д суурилсан программ хангамжийн борлуулалтаа нэмэгдүүлж, зардлаа оновчилсноор ашигт ажиллагаагаа шинэ түвшинд гаргах хүлээлттэй байна.

Гэсэн хэдий ч 2026 оны хөрөнгө оруулалтын орчинд дараах томоохон эрсдэлүүд нүүрлэж байна:

- Ойрхи Дорнод дахь Иран, Израил болон АНУ-ын оролцоотой шууд мөргөлдөөн даамжирч байгаа нь дэлхийн эрчим хүчний үнэ болон тээвэр логистикт сөргөөр нөлөөлж, технологийн компаниудын нийлүүлэлтийн сүлжээнд тодорхойгүй байдал үүсгэж байна.
- АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын засаг захиргаанаас хэрэгжүүлж буй худалдааны тарифын хатуу бодлого болон цагаачлалын шинэчлэлүүд нь инфляцыг өдөөж, Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ өндөр түвшинд хадгалахад хүргэж болзошгүй юм. Энэ нь технологийн салбарын үнэлгээ болон өсөлтийн төлөвт дарамт учруулж байна.
- Протекционист бодлогоос үүдэлтэй олон улсын худалдааны маргаан болон бараа бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэргүй байдал нь хөрөнгийн зах зээлийн хэлбэлзлийг (volatility) нэмэгдүүлэх үндсэн хүчин зүйл болохоор байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗАСАГЛАЛ

Хөрөнгө оруулалтын сангийн удирдах дэд бүтэц нь нэгж эрх эзэмшигчдийн хурал байх ба жилдээ нэг удаа хуралдана. Нэгж эрх эзэмшигчдийн Төлөөлөн удирдах зөвлөл улирал бүр хуралдаж нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалтын зөвлөхийг үр ашигтай удирдлагаар хангах, стратегийн хэрэгжилтийг хянах, үнэлэлт дүгнэлт өгөх үүрэгтэй. Сангийн ТУЗ нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй ба 2 гишүүн нь хараат байна. ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь Сангийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх чадвар бүхий хөрөнгө оруулалтын салбарт мэргэжлийн өндөр ур чадвар, ёс суртахуунтай гишүүдээс бүрдсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

Албан тушаал	Нэр	Албан тушаал
ТУЗ-ийн дарга	С.Тулга	Санхүү удирдлага, хөрөнгө зохицуулалтын газрын захирал, Инвескор ББСБ ХК
ТУЗ-ийн гишүүн	Л.Билгүүн	Гүйцэтгэх захирал, Инвескор Капитал ҮЦК ХХК
ТУЗ-ийн гишүүн	Б.Мөнгөнзул	Үйл ажиллагаа хариуцсан захирал, Инвескор Ассет Менежмент ҮЦК ХХК
ТУЗ-ийн хараат бус гишүүн	О.Лхагвасүрэн	Санхүү, хөрөнгө оруулалтын зөвлөх компани “Сэцэн Билгүүн ХХК”-ийг үүсгэн байгуулагч, захирал
ТУЗ-ийн хараат бус гишүүн	Б.Мөнхзаяа	Санхүү Эдийн Засгийн Их сургууль Бакалаврын сургалт, судалгаа хариуцсан проректор

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС, УДИРДЛАГА

Дагалтын алдаа (Tracking Error)

Дагалтын алдааг улирал бүр тооцоолон алдааны үндсэн шалтгааныг тогтоож дараагийн саруудад давтагдахгүй байх алхмуудыг Хөрөнгө оруулалтын зөвлөх авч хэрэгжүүлэн ХОМК-ийн эрх бүхий субъектэд танилцуулж шийдвэрлүүлнэ.

Индексийн жил бүрийн 12 дугаар сард хийгдэх дахин бүтэцжүүлэлттэй нийцтэй байхын тулд 10 дугаар сарын сүүлийн зах зээлийн өгөгдөл болон 11 дүгээр сарын багц хувьцааны тоо ширхгийн мэдээнд үндэслэн индексийн бүрэлдэхүүнд орох болон гарах үнэт цаасны өөрчлөлтийг урьдчилан таамаглана.

Индексийн улирал бүр хийгдэх дахин тэнцвэржүүлэлттэй урьдчилсан нийцүүлэхийн тулд сангийн хөрвөх чадварыг хангаж, багцын дахин тэнцвэржүүлэлтийг хийх дүрэмтэй байна.

Индексийн үнэ цэн буурах

Зах зээлийн индекс унах үед индексийн уналтаас хөрөнгийн үнэ цэнийг хамгаалах зорилгоор үйлдэл хийх боломжгүй. Гэвч индексийн уналтаас илүү уналт үзүүлэхгүйн тулд багцын VaR, CVaR болон стандарт хазайлтыг улирал бүр тооцож, дахин тэнцвэржүүлэлт хийнэ.

Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл нь сангийн эзэмшиж буй хувьцаануудын хөрвөх чадвар буурах, сан нь зардал болон нэгж эрхийн буцаан авалтад хүрэлцэх мөнгөн хөрөнгөгүй болохыг хэлнэ.

Сангийн багцад багтаж буй үнэт цаасны тоо хэмжээ нь тухайн үнэт цаасны өдрийн дундаж арилжааны хэмжээний 0.1% (тэг аравны нэг хувь)-аас хэтрүүлэхгүйгээр хязгаарлах.

Нэг компанийн хувьцаанд оруулах хөрөнгө оруулалтын дүн, ХБАС-ийн нийт активын 14% (арван дөрвөн хувь)-аас хэтрэхгүй байна. Индексийн тооцоололд 1 (нэг) компанийн хувийн жингийн хязгаарлалтыг 14% (арван дөрвөн хувь)-аар тогтоосон болно.

ХБАС-ийн нэгж эрх солилцох багц хувьцаанд хамгийн өндөр хувийн жин эзэлж буй 5 (тав) компанийн хувьцааны нийлбэр дүн нь нийт багцын дүнд эзлэх нийлбэр хувийн жин 38.5% (гучин найм аравны таван хувь)-аас хэтрэхгүй байна.

Тогтмол орлоготой, нэг жилээс дээш хугацааны эргэн төлөлттэй үнэт цаасанд ХБАС-ийн активын 5% (таван хувь)-аас дээш хувиар хөрөнгө оруулалт хийхгүй.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлан (2025 оны 12-р сарын 31-ний өдөр)

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,454,575.93	3,347,720.11
Дансны авлага	-	-
Татвар, НДШ-ийн авлага	-	-
Бусад авлага	-	-
Бусад санхүүгийн хөрөнгө	96,940,966.61	170,760,403.75
	-	-
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн:	**101,395,542.54**	**174,108,123.87**
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	-	-
Биет бус хөрөнгө	-	-
	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн:	**-**	**-**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН:	**101,395,542.54**	**174,108,123.87**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	23,862,885.77	4,799,189.79
Цалингийн өглөг	-	-
Татварын өр	-	-
НДШ-ийн өр	-	-
Богино хугацаат зээл	-	-
Хүүгийн өглөг	-	-
Ногдол ашгийн өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	-	-
Нөөц /өр төлбөр/	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн:	**23,862,885.77**	**4,799,189.79**
Урт хугацаат өр төлбөр		
	-	-
Нөөц /өр төлбөр/	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн:	**-**	**-**
Өр төлбөрийн нийт дүн:	**23,862,885.77**	**4,799,189.79**
Эздийн өмч		
	-	-
- Хувь нийлүүлсэн хөрөнгө	78,785,866.36	134,785,585.42
	-	-
Халаасны хувьцаа	-	-

Нэмж төлөгдсөн капитал	-	-
	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг	(1,253,209.59)	34,523,348.66
Эздийн өмчийн дүн	**77,532,656.77**	**169,308,934.08**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН:	**101,395,542.54**	**174,108,123.87**

Орлогын Дэлгэрэнгүй тайлан (2025 оны 12-р сарын 31-ний өдөр)

Үзүүлэлт	2024 он	2025 он
Борлуулалтын орлого (цэвэр)	**-**	**-**
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)	-	-
	-	-
Хүүний орлого	-	-
Ногдол ашгийн орлого	1,714,049.80	481,467.73
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	-	-
Борлуулалт, маркетингийн зардал	-	140,000.00
Ерөнхий ба удирдлагын зардал	(44,184,281.60)	11,215,570.54
Санхүүгийн зардал	-	-
Бусад зардал	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(153,080.79)	(101,387.66)
	-	-
	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	9,618,312.07	46,472,048.72
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	**(33,005,001.52)**	**35,776,558.25**
Орлогын татварын зардал	-	-
Татварын дараах ашиг (алдагдал)	**(33,005,001.52)**	**35,776,558.25**
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	**-**	**-**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	**(33,005,001.52)**	**35,776,558.25**
Бусад дэлгэрэнгүй орлого	**-**	**-**
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	**(33,005,001.52)**	**35,776,558.25**
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	**(202)**	**119.65**

Мөнгөн гүйлгээний тайлан (2025 оны 12-р сарын 31-ний өдөр)

Үзүүлэлт	2024 он	2025 он
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	55,999,719.06
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	55,999,719.06
	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгө гүйлгээний дүн	**-**	**55,999,719.06**
Валютын ханшийн зөрүү	(153,080.79)	-54,529.98
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**(9,794,402.59)**	**(1,106,855.82)**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**14,248,977.52**	**4,454,575.93**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**4,454,575.93**	**3,347,720.11**

ХАВСРАЛТ

Мэргэжлийн оролцогч ҮЦК

INQ ETF –ийн нэгж эрхийн хөрвөх чадварын ханган зах зээл үүсгэгчийн гэрээ байгуулан ажиллаж буй ҮЦК-аар дамжуулан нэгж эрхийн арилжаанд оролцсоноор таны захиалга илүү хурдан биелэх боломжтой.

- ✓ “Инвескор Капитал ҮЦК” ХХК: www.icapital.mn; 7755-0077
- ✓ “Таван Богд Капитал ҮЦК” ХХК: www.tavanbogdcapital.com; 7272-7282
- ✓ “Ард Секюритиз ҮЦК” ХХК: www.ardsecurities.com; 7700-3322
- ✓ “Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК: www.tdbsecurities.mn; 70100261

Нэр томьёо

“ХОМК” гэж ХБАС-ийг үүсгэн байгуулж хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу ХБАС-ийн хөрөнгийг удирдах эрх бүхий этгээд болох “Инвескор Ассет Менежмент ҮЦК” ХХК–ийг;
“Хөрөнгө” гэж ХБАС-ийн өмчлөлд буй бүх төрлийн санхүүгийн хэрэгсэл, эд хөрөнгө болон тэдгээрийн эрхийг;
“Мэргэжлийн оролцогч” гэж ХОМК-тай Мэргэжлийн оролцогчийн гэрээ байгуулсан, хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй брокер, дилерийг хэлэх ба сангийн нэгж;
“Үнэт цаас” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т тодорхойлсон санхүүгийн хэрэгслийг;
“Нэгж эрх” гэж хөрөнгө оруулагчаас ХБАС-д оруулсан хөрөнгийн өмчлөх эрхийг гэрчлэх нэрийн үнэт цаасыг тус тус ойлгоно.

GOLOMT BANK
Investing for a brighter future

INVESCORE GLOBAL Q

VISION

Mongolia’s Global Benchmark Bank

MISSION

The genesis of Prosperity

КАСТОДИАН БАНК

Инвескор Глобал Кью ХБА ХОС

Кастодиан үйлчилгээний тайлан

2025 ОН

MISSION

The genesis of Prosperity

VISION

Mongolia’s Global Benchmark Bank

Голомт Кастодиан Банк

Голомт Банк нь кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бөгөөд мэргэшсэн чадварлаг хүний нөөц, олон улсын стандарт нийцсэн кастодиан банкны үндсэн бүртгэлийн систем дээрээ суурилан Монгол улсад кастодиан банкны үйлчилгээг бүрэн үзүүлж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (46.1)-т зааснаар "Үнэт цаас өмчлөгчийн өмчлөл дэх үнэт цаасыг хадгалах, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх бусад эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх ажиллагааг кастодианы үйл ажиллагаа" гэнэ.

Голомт банк нь 2014 оны 08 сарын 27-ны өдөр хамгийн анхны кастодиан банкны тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан билээ. Мөн 2017 оны 12 сарын 15-нд үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагааг хавсран эрхлэх нэмэлт тусгай зөвшөөрлийг авснаар хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг бүртгэж хадгалах, төлбөр тооцоог гүйцэтгэх, компанийн үйл ажиллагаанд төлөөлөхөөс гадна нэгж эрхийн тухайлсан бүртгэл хөтлөх, нэгж эрхийн цэвэр үнэлгээ тооцоолох зэрэг цогц үйлчилгээг хөрөнгө оруулалтын менежментийн компаниас хараат бусаар гүйцэтгэж, хөрөнгө оруулагчид болон зохицуулагч байгууллагад сангийн талаар бие даасан мэдээлэл хүргүүлж ажиллаж байна.

1,800 гаруй дотоодын, гадаадын иргэн, байгууллагын үнэт цаасны хадгаламжийн дансыг нээж кастодианы тухайлсан бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна. Мөн нийт 30 гаруй хөрөнгө оруулалтын сангуудад үйлчилгээ үзүүлж, 30 гариу брокерын компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан Монголын хамгийн том кастодиан банк болоод байна.

ОН	ҮЙЛ ЯВДАЛ
2014	Кастодианы тусгай зөвшөөрлийг хамгийн авж, Монгол улсад анх удаа Касодиан үйлчилгээг нэвтрүүлэв.
2015	Үйлчилгээний нээлтийг албан ёсоор хийв Японы Nomura ICS системийг нэвтрүүлсэн Анхны харилцагчаа бүртгэв.
2016	MIT системтэй бүрэн холболт хийв Төвлөрсөн хадгаламжийн гишүүн болов.
2017	Глобал кастодианы шаардлагыг бүрэн хангаж саб-кастодиан болов Үнэт цаасны тухайлсан бүртгэлийн зөвшөөрөл авсан.
2018	Олон улсын ISAE 3402 стандартыг хангав.
2019	ICBC хамтын ажиллагааг эхлүүлэв Гадаад төлбөр, тооцоо гүйцэтгэх болсон
2020	Клирингийн Ерөнхий Гишүүн болов Хамгийн анхны хамтын ХОС-д цогц үйлчилгээ үзүүлж эхэлсэн
2021	КЕГ-ийн хүрээнд клирингийн болон төлбөрийн үйлчилгээ үзүүлж эхлэв.
2022	Хамгийн том хамтын ХОС-д цогц үйлчилгээ үзүүлж эхэлсэн Клирингийн бус 3 гишүүнийг элсүүлж, клирингийн болон төлбөрийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн.
2023	*Хамтын Биржээр Арилжаалагддаг ХОС-д үйлчилгээ үзүүлж эхлэв.*
2024	*Зах зээл эзлэх байр суурыа нэмэгдүүлж, Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй нийт ХОС-гийн тэн хагаст үйлчилгээ үзүүлэв.*
2025	*ББЗЗ-ийн системийн холболт хийсэн Гадаад харилцаагаа тэлж Евроклир ОЦ-ын хадгаламжийн төвтэй хамтын ажиллагаа эхлүүлсэн*

Үйлчилгээний гэрээ

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 49-р зүйлд Кастодианы зүгээс хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих, үйлчилгээ үзүүлэхэд анхаарах дараах зүйлсийг шаарддаг бөгөөд ХОС–тай байгуулсан “Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээ”-нд нэг бүрчилж тусган ажиллаж байна.

2023 оны 08 сарын 01-ны өдөр Голомт банк болон “Инвескор Ассет Менежмент ҮЦК” ХХК нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудын хүрээнд “Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээ” байгуулснаар Голомт банк нь “Инвескор Глобал Кью Хамтын Биржээр Арилжаалагддаг ХОС”–д оруулсан хөрөнгө оруулалтыг нь бүртгэж хадгалах, үнэт цаас худалдаж авахтай холбоотой төлбөр тооцоог гүйцэтгэх, хүүгийн болон ногдол ашиг цуглуулах, нэгж эрхийн тухайлсан бүртгэл хөтлөх, хөрөнгийн цэвэр үнэлгээ тооцоолж цогц үйлчилгээг үзүүлэх болсон. “Инвескор Глобал Кью Хамтын Биржээр Арилжаалагддаг ХОС”-ын нэр дээр кастодианы тусгайлсан данс нээж бүх төрлийн хөрөнгө оруулалт, үнэт цаасыг бүртгэн хадгалж, ангилал төрлийг тодорхой зааж, хадгалалтын нууцлал, бүрэн бүтэн байдлыг ханган ажиллаж байна.

Гэрээнд дараах үйлчилгээнүүдийг нарийвчлан тусгаж, үйлчилгээний нөхцөл, талуудын үүрэг хариуцлага, бусад харилцааг зохицуулсан.

- Сангийн хөрөнгө бүртгэж хадгалах,
- Төлбөр тооцоо гүйцэтгэх
- Компаний үйл ажиллагаа
- Нэгж эрх тухайлсан бүртгэл хөтлөх
- Нэгж эрхийн цэвэр үнэлгээ тооцоолох
- Тайлан мэдээ боловсруулж илгээх

Хөрөнгө хадгалах үйлчилгээ

2025 онд “Инвескор Глобал Кью Хамтын Биржээр Арилжаалагддаг ХОС”-ийн нийт удирдаж буй хөрөнгө өмнөх оноос 58.1% өсөлтийг үзүүлсэн байгаа ба багцыг нийт үнэлгээ 174.1 сая төгрөгт хүрч, 168 нэгж эрх эзэмшигчийн 7.9 сая сангийн нэгж эрхийг хаалттай хүрээнд зах зээл нийлүүлээд байна.



Хадгалж буй хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээ

“Инвескор Глобал Кью Хамтын Биржээр Арилжаалагддаг ХОС”-гийн нийт удирдаж буй хөрөнгө 2025 оны эцсээр 174.1 сая төгрөгийн үнэлгээтэй байгаа ба нийт хөрөнгийн 98%-ийн гадаад компаний хувьцаа, 2%-ийг бэлэн мөнгө болон хадгаламжинд байршуулаад байна.



Нэгж эрхийн тухайлсан бүртгэл

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-д “хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг тухайн санд үйлчилгээ үзүүлж байгаа кастодиан хөтөлнө” гэж заасан байдаг. “Инвескор Глобал Кью Хамтын Биржээр Арилжаалагддаг ХОС”-н хөрөнгийг хадгалдаг кастодианы хувиар дээр дурьдсан гэрээний хүрээнд Голомт банк нь нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг хөтлөх үйлчилгээг үзүүлж байна. **2025 оны 12 сарын 31**-ний өдрийн байдлаар нэгж эрх эзэмшигчдын бүртгэл дараах байдлаар байна.

		Харилцагчийн тоо		Нэгж эрхийн тоо ширхэг	
Ашид		2024	2025	2024	2025
Нэгж эрх эзэмшигч	Иргэн	169	164	79,883	79,883
	Байгууллага	5	4	83,595	219,122
Нийт		174	168	163,478	299,005

Нэгж эрхийн цэвэр үнэлгээ

“Инвескор Глобал Кью Хамтын Биржээр Арилжаалагддаг ХОС”-ийн нэгж эрх нь Улаанбаатар үнэт цаасны биржээр арилжаалагддаг бөгөөд нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг Кастодиан банк хөтөлдөг.

“Инвескор Глобал Кью Хамтын Биржээр Арилжаалагддаг ХОС”-ын нэгж эрхийн үнэлгээ нь тухайн сангийн вэб хуудас болон Улаанбаатар үнэт цаасны биржээр дамжуулан олон нийтэд мэдээлэгддэг бол кастодиан банкнаас цэвэр үнэлгээнд давхар тооцоолол баталгаажуулан тухай бүр тулган хамтран ажилладаг.



Хөрөнгө оруулалтын менежментийн компанитай тухай бүр үнэлгээний тулгалтыг кастодиан банк хийх бөгөөд Сангийн нэгж эрхийн цэвэр үнэлгээг тооцоход хөрөнгө оруулалтын хэрэгслийн бүртгэл, зах зээлийн үнэлгээний өөрчлөлт зэрэг тухай бүр тооцогддог.

Кастодиан банк нь 2025 онд нэгж эрхийн цэвэр үнэлгээ өдөр алгасангүй (365) тооцоолж санд хүргүүлсэн байна. Өдөр бүр сангийн хөрөнгийн бүхий л түвшинд тулган баталгаажуулж хамтран ажиллаж байна.

Нэгж эрхийн цэвэр үнэлгээ 566.24 төг хүрсэн ба өмнө оноос 83.7% хувийн өсөлтийг үзүүлсэн байна.

2025.12.31-ний байдлаар хуримтлагдсан өглөг 4.8 сая төгрөг байгаа ба сангийн удирдаж буй хөрөнгийн 3%-тай тэнцэхүйц байна.

Төлбөр тооцоо

2025 онд кастодиан банк нь дараах төлбөр тооцоо бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

- 42 төрлийн 170 мянган ам.долларын үнэлгээ бүхий гадаад хувьцааны арилжааг зохионг байгуулав.

Сар	Авах / Зарах	Нийт тоо ширхэг	Нийт үнийн дүн
3	SFD	135,527.00	135,527.00
	SFR	135,527.00	135,527.00
	Нийт	135,527.00	135,527.00
	Нийт	**135,527.00**	**135,527.00**

- Мөнгөн хөрөнгийн 58.2 сая.төгрөг бүхий 64 удаагийн гүйлгээ гараас гүйцэтгэв.

Сар	Мөнгөн дүн	Сар	Мөнгөн дүн
1	1,343,287..73	7	200,000.00
2	5,842,950.00	8	2,750,853.37
3	262,200.00	9	122,200.00
4	1,071,700.00	10	1,601,820.00
5	100,000.00	11	40,085,354.00
6	301,960.00	12	4,727,100.00
	Нийт		**58,209,425.01**

Компанийн үйл ажиллагаа

Харилцагчийн үнэт цаастай нь холбогдон гарах бүх төрлийн компанийн үйл ажиллагааг түргэн шуурхай мэдээлэх ба харилцагчаас ирүүлсэн зааврын дагуу компанийн үйл ажиллагаанд төлөөлөн оролцож холбогдох эрхүүдийг хэрэгжүүлдэг. 2025 онд дараах үйлчилгээг үзүүлэв.

“Инвескор Глобал Кью Хамтын Биржээр Арилжаалагддаг ХОС” нь тайлант жилд ногдол ашиг зарлаж , олгоогүй байна.

Тайлан мэдээлэл / Тулгалт /

Сангийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг ХОМК-с өдөр бүр гүйлгээний даалгавар, нэгтгэсэн кастодианы зааварчилгааг хүлээн авч тухай бүр бүртгэл, гүйлгээг хийж, цэвэр хөрөнгийн үнэлгээнд зөрүү үүсэх эрсдлээс урдчилан сэргийлж, хөрөнгийн бүртгэлийг зөрүүгүй хийж гүйцэтгэхээр бүртгэлийн ажлыг зохион байгуулж байна.

Кастодианы бүртгэлийн системээс дараах тайлан харилцагч ХОС-д автоматаар тухай бүр гарч харилцагчдад мэдээлэл хүргүүлдэг.

Тайлангийн нэр	Тайлангийн нэр	Давтамж
Нэгж эрх эзэмшигчдийн бүртгэл	Нэгж эрх эзэмшигч бүрийн мэдээлэл, эзэмшиж буй нэгж эрхийн хэмжээ,	Өдөр бүр
Нэгж эрхийн цэвэр үнэлгээний тайлан	Санхүүгийн хэрэгсэл бүр дэх үнэт цаас бүрийн тоо ширхэг, зах зээлийн үнэ, нэгж эрхийн тоо ширхэг, нэг нэгжийн үнэлгээ	Өдөр бүр
Цэвэр хөрөнгийн үнэлгээний тайлан	Санхүүгийн хэрэгсэл бүр дэх үнэт цаас бүрийн тоо ширхэг, худалдан авсан үнэ, зах зээлийн үнэ г.м.	Өдөр бүр
Дансны дэлгэрэнгүй хуулга	Тухайн сард гасан хөрөнгийн өөрчлөлт, хийгдсэн гүйлгээний мэдээлэл	Сар бүр
Хөрөнгө оруулалтын багцын тайлан	Хөрөнгө оруулалтын багцын тайлан Багцад байгаа санхүүгийн хэрэгсэл бүрээр хөрөнгийн хэмжээг харах боломжтой.	Өдөр бүр
Арилжааны тайлан	Үнэт цаасны арилжааны дэлгэрэнгүй тайлан	Тухай бүр
Гүйлгээний тайлан	Үнэт цаасны гүйлгээ, бүртгэлийн дэлгэрэнгүй тайлан	Тухай бүр
Компанийн үйл ажиллагааны мэдэгдэл	Компанийн цаг үеийн мэдээллээр хангах, эзэмшиж буй үнэт цаастай холбоотой мэдээллийг хүргүүлэх тайлан	Тухай бүр
Жилийн үйл ажиллагааны тайлан	Кастодиан банк ХОС-д үзүүлсэн үйлчилгээний жилийн тайлан	Жил бүр

КАСТОДИАН БАНКНЫ ХЭЛТЭС

2025 он